



ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨВ АЙМАГ ДАХЬ ХЭЛТЭС

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх

хаягаар холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272582

И-мэйл Jargalsaikhan_tuv@yahoo.com

Аудитын багийн Аудитор

Ц.Саранчимэг

Утас: 70273204

И-мэйл Tsaranchimeg@yahoo.com

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

• Танилцуулга	3
• Санхүүгийн дотоод хяналт	3
• Гол шийдлүүд	4
• Залруулаагүй алдаа	4
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	4
• Аудитын санал дүгнэлт	4

Тагнуулын хэлтсийн 2013 оны Санхүүгийн Тайланд
Аймгийн Аудитын газар аудит хийж дууссан тухай мэдэгдэл

1.Бид Тагнуулын хэлтсийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Тагнуулын хэлтсийн төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Тагнуулын хэлтэс тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**

Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

Аудитыг дуусгаж аудитаар илэрсэн санхүүгийн тайланд нөлөөлж болох зөрчил нь материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага байгаа тул **Зөрчилгүй санал дүгнэлт** гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа

Ерөнхий аудитор 2014.01.29-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч В.Оюунчимэг болон бусад бидэнтэй хамтран ажилласан явдалд талархаж байна.

2014.01.29

Танилцуулга

1. Бид Тагнуулын хэлтсийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Тагнуулын хэлтсийн даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаар бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Тагнуулын хэлтэс тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитнаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх

2. Аймгийн Аудитын газар жилийн санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалтын үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

3. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Тагнуулын хэлтсийн удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Санхүүгийн дотоод хяналтын талаар

МУЗГазрын 2011.11.09 –ний өдрийн 311-р тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам батлагдсан байна. “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” –ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө гэсэн заасны дагуу Тагнуулын Ерөнхий газарт Дотоод аудитын баг ажиллаж байна. Гэвч 2013 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

2. Орлого, санхүүжилтийн талаар

Тагнуулын Ерөнхий газраас Төв Аймгийн хэлтсийн 2013 оны урсгал зардлын төсвийг 103193.3 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд гүйцэтгэлээр 102055.8 мянган төгрөгийн санхүүжилт, 1136.6 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогоор эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Мөнгөн гүйлгээний тайланд нийт 103192.4 мянган төгрөгийг орлогоор тайлагнасан байна. Үндсэн үйл ажиллагааны орлогоор суурин утасны төлбөр 5000 төгрөг нийт 746.7 мянган төгрөг, Улсын бүртгэлийн хэлтсээс тусгай шуудангийн төлбөрт 389.9 мянган төгрөгийн орлого тус тус орсон байна.

3. Үндсэн хөрөнгө

Тагнуулын хэлтсийн 2013 оны санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгө 3384.3 мянган төгрөгөөр нэмэгдэж 2111.0 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна. Үүнд: Тоног төхөөрөмж дансанд Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн төв аймаг дахь салбар зөвлөлөөс зөөврийн компьютер 918.4 мянган төгрөгөөр, бялдаржуулах төхөөрөмж 1500.0 мянган төгрөг, ТЕГазраас 965.9 мянган төгрөгийн зөөврийн компьютер

орлого авч хөрөнгө нэмэгдсэн байна. Мөн тоног төхөөрөмжийн данснаас Төрийн өмчийн хорооны 2013 оны 19-ний өдрийн 4/398 тоот тушаал, ТЕГазрын 2013.07.17-ны өдрийн а/65 тоот тушаалыг үндэслэн принтер, компьютер, микрофоныг акталж хасах шийдвэр гарсаны дагуу хөрөнгийг данснаас хассан байна.

4.Бараа материал

Тус байгууллага нь бараа материал дансанд 9746.3 мянган төгрөгийн орлогын, 8702.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн байна. Түлш шатах тослох материалын дансанд 6772.3 мянган төгрөгийн орлого зарлагын гүйлгээ хийгдсэн нь мөнгөн гүйлгээний тайлангаар бүрэн зарцуулсан байна. Шатахууныг олгохдоо замын хуудас бичдэг жолоочийн замын хуудасны тооцоог бодсон байна. ТБОНӨТХуулинд заасны дагуу Бараа материалын хөрөнгийн тооллогыг хийж, тооллогын комисс дүнг илтгэх хуудсаар тайлагнасан байна. Тооллогын комисс хариуцлагатай ажиллаж ашиглалтгүй актлах хөрөнгийн саналыг жагсаалтаар гаргаж ТЕГазарт хүргүүлсэн байна.

5.Цалингийн талаар

Харилцахын журналаас түүвэрлэхэд Цалингийн зардалд 77848.5 мянган төгрөг тайлагнагдсан. Тус хэлтсээс 2013 онд хэлтсийн ажилтнуудад хоолны хөнгөлөлт гэж нэг ажилтанд өдөрт 1500 төгрөгөөр бодож нийт ажилтнуудад жилд 2716.5 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт , нэг ажилтанд 800 төгрөгийн унааны хөнгөлөлт жилд 1448.8 мянган төгрөг нийт 4165.3 мянган төгрөгийн хоол , унааны хөнгөлөлт олгосон байна. Нэмэгдэл цалинд төрийн алба хаасан, онцгой нөхцөл, цол, төрийн нууц, ур чадвар, үр дүнгийн урамшуулалд нийт 21031.5 мянган төгрөг, ээлжийн амралт болон цалингийн зөрүү 7782.3 мянган төгрөг олгосон байна. Цалингийн арга хэмжээ авагдаж суутгуулсан 239.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг цалингийн зардлаа бууруулан өглөгийг хаасан байна.

6.Бараа үйлчилгээний зардал

Бараа үйлчилгээний зардал нь батлагдсан төлөвлөгөөгөөр 22251.6 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар гүйцэтгэлээр 22250.7 мянган төгрөг зарцуулж батлагдсан төсвийг 0.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна. Нийт бараа үйлчилгээний урсгалд зардлын 48.72 хувийг буюу 10839.5 мянган төгрөг, бусад бараа үйлчилгээний зардал 51.28 хувийг эзэлж байна.

7.Мөнгөн хөрөнгө

Харилцах дансанд 105296.3 мянган төгрөгийн орлого орж , 105296.3 мянган төгрөгийн зарлага гарсан байна. Засгийн газрын 2012 оны 205 тоот тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журам-ын 7.11.4-д “нийгмийн даатгалын сан, даатгалын компаниас тухайн даатгуулагчтай холбоотой даатгалын төлбөрийг тухайн байгууллагын данснаас орлого бууруулах бичилт хийнэ “ гэж заасны дагуу жирэмсний амралтын 1645.3 мянган төгрөг, татварын хөнгөлөлт буцаан олголт 458.6 мянган төгрөг бүгд 2103.9 мянган төгрөгийн орлогыг бууруулан тайлагнасан байна.

8.Авлага ,өглөгийн талаар

Тус хэлтэс нь авлага өглөгийн оны эхний болон эцсийн үлдэгдэлгүй тайлагнагдсан ба харилцагч байгууллагуудаас Нийгмийн Даатгал, Татварын тооцоог хийж тооцоо нийлсэн бусад байгууллагатай тооцоо нийлсэн акттай байна. Биет сорил хийхэд дараах байгууллагуудтай тооцоо нийлсэн актыг бүрэн стандартын дагуу хийсэн байна.

Тус хэлтэс нь Би Ти Эм Эс ХХК, ШҮГазар, Мандухай цэцэн ХХК, МТТөв ХХК, УБХэлтэс, Холбоо, Цахилгаан эрчим хүч, Төв Чандмань ДЭХГ зэрэг байгууллагуудтай тооцоо нийлсэн байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 8 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохитой үндэс болсон нь нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудитын явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- ✓ Албан томилолтын тооцоог хийхдээ ажил гүйцэтгэсэн тэмдэглэл болон томилолтын тооцоог хийхийг зөвшөөрсөн цохолтыг бүрэн хийж байх
- ✓ Цалингийн торгуулийн арга хэмжээ авсан тохиолдолд орон нутгийн орлогын дансанд торгуулийн орлогыг тухай бүрд нь шилжүүлж байх

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

6. Аудитын стандарт нь аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Залруулагдаагүй алдаанууд байгууллагын удирдлагын анхаарлын төвд хүргэгдэх болно. Сангийн сайдын 2013 оны 12-р сарын 02 ны өдрийн 269 тоот тушаалын дагуу үнэ төлбөргүй бэлтгэсэн үндсэн хөрөнгийн бичилтийг Засгийн газрын капитал данснаас Бусад орлого 140505 данс руу залруулах бичилт хийсэн болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

7. Аудитын үйл явцад аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторовн хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

Аймгийн аудитын газраас тус тайланд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага байгаа тул **Зөрчилгүй санал дүгнэлт** гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.01.29